

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2013 оны 9 дүгээр сарын 06

Тендер шалгаруулалтын нэр: **“10 аймгийн төвийн инженерийн байгууламж шугам сүлжээг шинэчлэх, шинээр байгуулах /Архангай, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Орхон/- ХХ1.1.73” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ХААГ-А-2013/ХХ1-36**

Худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“10 аймгийн төвийн инженерийн байгууламж шугам сүлжээг шинэчлэх, шинээр байгуулах /Архангай, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Орхон/- ХХ1.1.73” ажлын 1, 2, 5, 6, 7, 8 дугаар багцын ажил**”-ыг гүйцэтгэх тухай **цахим тендер** ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.meps.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын (www.e-procurement.mn) дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **20,000 (хорин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер нь дараах нэр багцуудаас бүрдэнэ. Үүнд:

Багц-1. “Хонгор-1000 орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ /Баянхонгор/”

Багц-2. “Сайншанд сумын дулааны шугамын өргөтгөл /Дорноговь/”

Багц-5. “Орон сууцны инженерийн шугам сүлжээний шинэчлэлт /Орхон/”

Багц-6. “Орон сууцны хэрэгцээний халуун усанд холбох /Өмнөговь/”

Багц-7. “Хөвсгөл Тайсун орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ /Хөвсгөл/”

Багц-8. “Орон сууцны 7 дугаар хорооллын гадна инженерийн шугам сүлжээ /Орхон/”

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Сүүлийн 3 жилийн борлуултын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 20 хувиас багагүй байна.
- Сүүлийн 3 жилд хамгийн багадаа нэг удаа санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй ажлыг гүйцэтгэсэн байна.

Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай:

Багц-1: ЭХЯамны: 03.2.1. Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар 0.4-10кВ, **03.3.1.** 115-250°С температуртай, 0.7-16.0кгх/см² даралттай зуухны угсралт, засвар, **БХБЯамны: 2.1.2.** Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил, **2.2.3.** Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт, **2.2.5.** Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт

Багц-2, Багц-6: 2.2.5. Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт,

Багц-5: 2.2.3. Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт, 2.2.5. Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт,

Багц-7: ЭХЯамны: 03.2.1. Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар 0.4-10кВ, **2.2.3.** Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт,

Багц-8: 2.2.3. Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт, 2.2.4. Холбоо дохиолол, интернет, компьютерийн сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт,

Тендерийн хамт дараах дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Багц-1: 56,000,000 (тавин зургаан сая) төгрөг

Багц-2: 3,400,000 (гурван сая дөрвөн зуун мянга) төгрөг

Багц-5: 16,000,000 (арван зургаан сая) төгрөг

Багц-6: 16,500,000 (арван зургаан сая таван зуун мянга) төгрөг

Багц-7: 8,000,000 (найман сая) төгрөг

Багц-8: 11,000,000 (арав нэгэн сая) төгрөг

Баталгааны хүчинтэй хугацаа: 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдрийг дуустал байна.

Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.

Тендерийг **2013 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 14:00 цагаас өмнө** цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2013 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 14 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхтэй**.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү **тооцно**.

Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулдаг цахим худалдан авах ажиллагааны төлбөргүй сургалтанд хамрагдахыг зөвлөж байна. Сургалтын утас: 7013-9970, 70110422

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их тойруу 80/1,
Нэг цэгийн үйлчилгээ, Утас: 70111090,
www.e-tender.mn, www.meps.gov.mn
www.e-procurement.gov.mn,